

Москва, Кремль.

**ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСЫН КОММУНИСТ НАМЫН
ТӨВ ХОРОО. ЗСБНХУ-ЫН ДЭЭД ЗӨВЛӨЛИЙН
ТЭРГҮҮЛЭГЧИД ЗСБНХУ-ЫН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛД**

Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Леонид Ильич Брежнев зуурдаар таалал төгссөн тухай гашуудалтай мэдээг сонсоод монголын коммунистууд, хөдөлмөрчин ард түмэн гүнээ эмгэнэж байна.

Олон улсын коммунист хөдөлгөөний гарамгай зүтгэлтэн, зөвлөлтийн Шмунистуудын авьяаслаг удирдагч, Зөвлөлт Холбоот Улсын дөрвөн удаагийн баатар, ЗСБНХУ-ын социалист хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын баатар, хөдөлмөрийн баатар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хүндэт иргэн Леонид Ильич Брежнев таалал төгссөнд гүнээ эмгэнэж байгаагаа Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид Сайд нарын Зөвлөл, монголын коммунистууд, хөдөлмөрчдийн өмнөөс Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын Төв Хороо, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, Зөвлөлүүдийн орны ард түмэнд илэрхийлж байна.

Л.И.Брежнев бол тууштай интернационалч, энх тайван, социализм коммунизмын үйл хэргийн төлөө цуцалтгүй тэмцэгч байсан юм. Жирийн ажилчнаас Лениний Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Зөвлөлт төрийн тэргүүн болтлоо түүний туулж өнгөрүүлсэн амьдралын гайхамшигтай бүх замнал нь ЗСБНХУ-д социалист, коммунист нийгэм байгуулах аугаа их үйл хэрэг, зөвлөлтийн ард түмний дэлхий дахины түүхэн ач холбогдол бүхий ололтыг хамгаалан арвижуулах, социалист орнуудын эв нэгдэл, нягт хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэлхийн бүх нутагт улс түмний энх тайван, аюулгүй байдлыг бататгах үйлсэд бүрэн зориулагдсан юм.

Манай хоёр нам, ард түмний ах дүүгийн эвдэршгүй найрамдал, нягт хамтын ажиллагааг бүх талаар бэхжүүлэхэд Л.И.Брежнев их хувь нэмэр оруулсныг Монголын ард түмэн хэзээ ч мартаггүй.

Хүнд бэрх 30-аад оны үед Леонид Ильич Брежнев Монгол оронд зөвлөлтийн цэргийн бүрэлдэхүүнд улс төрийн ажилтнаар ажиллаж байхдаа манай ард түмэнд ах дүүгийн тусламж үзүүлэхэд идэвхтэй оролцон, БНМАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнолыг империалист булаан эзлэгчдийн халдлагаас хамгаалах ариун үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж байсан нь монголын хөдөлмөрчдийн сэтгэл зүрхэнд үүрд орших болно.

Леонид Ильич Брежнев хүнлэг гайхамшигтай зан, хөдөлмөрийн хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нөхөрсгөөр анхаарал халамж тавьж соргогоор ханддаг чанараараа Монголын хот, хөдөөгийн хөдөлмөрчдийн гүн хүндэтгэл, талархлыг хүлээсэн юм.

Үнэнч ленинч, тууштай интернационалч, ард түмний зол жаргалын төлөө цогтой тэмцэгч Леонид Ильич Брежневийн гэгээн дурсгал монголын хөдөлмөрчдийн сэтгэл зүрхэнд үүрд хадгалагдах болно.

Талийгаачийн төрөл төрөгсөд, дотнын хүмүүст манай гүн эмгэнэлийг уламжилж өгөхийг хүсье.

МОНГОЛ АРДЫН
ХУВЬСГАЛТ
НАМЫН ТӨВ ХОРОО

БНМАУ-ЫН АРДЫН
ИХ ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИД

БНМАУ-ЫН
САЙД НАРЫН
ЗӨВЛӨЛ

Улаанбаатар 1982 оны арван нэгдүгээр сарын 11.